

Өнөөгийн япончуудын шүтлэгийн байдал ба шашныг үзэх үзэл

Д.Майсүлд, доктор (Ph.D), дэд профессор
МУИС, Ази судлалын тэнхим

Хураангуй: Уг өгүүлэлд өнөөгийн япончуудын шашин шүтлэгийн байдлыг тодруулахын сацуу япончуудын шашныг үзэх үзэл, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн талаар авч үзэхийг зорилоо.

Түлхүүр үг: шашин шүтлэг, шашныг үзэх үзэл, шинтоо шашин, буддын шашин

Гадаадын судлаачид япончуудыг “шашин шүтдэггүй”, “шүтлэггүй хүмүүс” хэмээн үздэг. Дэлхийн улс орнуудын шашин шүтлэгийн талаар хийсэн олон улсын судалгааны дүнгээс үзэхэд, ихэнх тохиолдолд япончуудыг “шашингүй үндэстэн” гэж дүгнэсэн байдаг. Мөн Японы судалгааны байгууллагуудаас хийсэн судалгаагаар ч өөрийгөө “шашингүй үзэлтэн” гэж хариулах хүмүүсийн хувь их байдаг, “шашин шүтдэг” гэж хариулсан ч хоёр ба түүнээс дээш шашин шүтдэг гэж хариулдаг гэх мэт япончуудын шашин шүтлэгийг шууд тодорхойлох боломжгүй байдаг. Бид энэ өгүүллээрээ япончуудын өнөөгийн шашин шүтлэгийн байдал хийгээд шашныг үзэх үзлийг авч үзлээ.

Японы уламжлалт шашин шүтлэг нь шинтоо шашин юм. Шинтоо шашны үүслийг МЭӨ IV зуунаас МЭ III зуунд хамааруулж үздэг. Газраар тэжээлгэж амьдардаг япончууд газрыг үлэмж шүтэн биширч, хүндэтгэж, газарт ер бусын бурханлаг хүч чадал оршдог хэмээдгээс улбаалж, япончуудын шашин шүтлэгийн мэдрэмж үзэл санаа үүсэж бүрэлдэн төлөвшиж тогтсон. Энэ шашин нь тусгайлан үүсгэн бий болгосон хүн үгүй бөгөөд тогтсон сургаал онол үгүй зэрэг нь уншлага тарнитай шашны хэлбэрээс ихээхэн ялгаатай (Т.Сансартуяа, 2009) шашин юм. Шинтоо шашин нь байгаль дээрх бүхий л зүйл эзэнтэй гэж үздэг. Тэрхүү эзнийг нь ками (神*) гэдэг.

Хожим VI зуунд Японд буддын шашин орж ирсэн бөгөөд шинтоо болон буддын шашны шашны нийлэгжих үзэгдэл олон зуун жилийн туршид өрнөсөн түүхтэй. Судлаачид уугуул шашин шинтоо нь “энхийг эрхэмлэх шашин” (和を好む) учраас шинтоо шашинт оронд буддын шашин нэвтрэн орж ирж нутагшиж чадсан гэж үздэг. Мөн аливаа зүйлийг нутагшуулж чаддаг япончуудын чадварыг газарзүйн онцлогтой холбоотой гэж үздэг. Харин христийн шашны тухайд, Мэижигийн үед (1868 оны үеэс) Японд орж ирж, соёлд тодорхой хэмжээнд нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал, Христийн мэндэлсний баяр, христийн сүмд хуримын ёслолоо хийх болсон зэргээр зан үйл, баяр ёслол нь нэвтэрчээ.

Юун түрүүнд Япон улсад шашин шүтэх талаар хэрхэн хуульчилсан байдгийг авч үзлээ. 1947 онд хүчин төгөлдөр болсон “Үндсэн хууль”-ийн 3-р бүлгийн 20-р зүйлд “Бүх хүн шашин шүтэх эрх чөлөө⁶⁵гөөр хангагдана” хэмээн заасан байдаг. Төрийн шашныг албан ёсоор зааж өгөөгүй байна. Түүнчлэн, *Ямар ч шашны байгууллага төрөөс тусгай эрх эдэлж, улс төрийн эрх мэдэл хэрэгжүүлэхийг хориглоно. Төр болон төрийн байгууллага шашны боловсрол болон бусад шашны үйл ажиллагаа явуулахыг хориглоно* (日本国憲法, 1946) гэж заасан байдаг.

*神- шинтоо шашны бурхан гэх ойлголт. Эзэн, сахиус гэх утга илэрхийлдэг.

⁶⁵ Шашин шүтэх эрх чөлөө-тодорхой шашин шүтэх, итгэл үнэмшлээ өөрчлөх эрх чөлөө, шашин шүтэхгүй байх эрх чөлөө мөн шашны баяр ёслол, арга хэмжээнд оролцох, мөргөл үйлдэх, эсвэл түүнээс татгалзах эрх чөлөө. Мөн шашны байгууллага байгуулах, шашны байгууллагад элсэх, үйл ажиллагаа явуулах, эсвэл элсэхээс татгалзах, үйл ажиллагаа явуулахгүй байх эрх чөлөө.


Улмаар, бид эрдэмтэн судлаачдын япончуудын шашин шүтлэгийн талаарх үзэл, тодорхойлолтыг авч үзлээ.

Румыны шашны гүн ухаан судлаач Mircea Eliade “Дэлхийн шашны тайлбар толь” бүтээлдээ “Япончууд бүхий л насаараа күнзийн сургаалын дагуу амьдарч, шинтоо шашны ёсоор хуримаа хийж, буддын шашны дэгээр оршуулгын ёслолоо хийж хорвоогоос буцдаг” (ミルチア エリアーデ, 1994) хэмээн япончуудын шашин шүтлэгийг томъёолсон байдаг.

Шашин судлаач Шимада Хироми (島田裕実) “Япончуудыг “шашингүй үзэлтэн” гэхээс илүүтэй үнэндээ өөрийгөө шашин шүтдэг гэж ухамсарладаггүй “шүтлэгтэй” хүмүүс гэж үзэх хэрэгтэй. Энэ нь тэд тодорхой шашны бүлгэмд харьяалагдах явдал багатай холбоотой. Өнөөгийн Японы нийгэмд шинтоо болон буддын шашин зэрэгцэн оршиж байна (島田裕実, 2020) гэсэн байна.

Япончуудын шашин шүтлэгийн өнөөгийн байдлыг тодруулахдаа олон улсын болон дотоодын дараах судалгааны дүнд тулгуурлав.

АНУ-ын мэдээллийн төв агентлагаас эрхлэн гаргадаг “The World Factbook” сэтгүүлд дэлхийн улс орнуудын хүн ам, газар зүй, харилцаа холбоо, улс төр, эдийн засаг зэргийн талаар судалгаа явуулж, үр дүнг нь нийтэлдэг байна. Дэлхийн олон улс орнуудын шашин шүтлэгийн талаар нийтэлсэн судалгааны дүнгээс үзэхэд, 2015 оны байдлаар, япончуудын 70,4% нь шинтоо



шашин, 69,8% нь буддын шашин, 1,5% нь христийн шашин, 6,9 хувь нь бусад шашин шүтдэг байна.

1968 онд Японы судалгааны төв (日本リサーチセンター) АНУ-ын Gallup International association байгууллагын гишүүн болж, япончуудын шашин шүтлэгийн талаарх судалгааг хийж эхлүүлсэн

байдаг. 2000 оны мэдээллээс үзэхэд, япончуудын 51,8 хувь буюу талаас илүү хувь нь шашингүй, 34,9 хувь нь буддын шашин, 3,9 % нь “Бусад”(шинтоо шашин) гэж гарчээ (「世界60カ国価値観データブック」).

Түүнчлэн 2005 онд судалгаанд оролцогчдын 64-65 % нь атейст (無神論者), агностик (不可知論者) гэж хариулсан байдаг. 2017 онд 66,000 мянган хүн судалгаанд хамрагдаж, 29% нь бурханд итгэдэггүй атейст үзэлтнүүд байдаг гэсэн дүн гарсан бөгөөд шашингүй үзэлтнүүдийнхээ хувь хэмжээгээр Япон улс Хятадын дараа дэлхийд хоёрдугаарт орсон байна.

NHK соёл судалгааны хүрээлэнгийн судалгааг япончуудын шашны шашин шүтлэгийн байдлыг тандах чухал судалгаа гэж үздэг. Учир нь, ISSP-Олон улсын харьцуулсан судалгааны группээс дэлхийн 40 орны судалгааны хүрээлэнгээр дамжуулан жил бүр тодорхой сэдвээр асуулга бэлтгэж, судалгаа явуулдаг байна. Судалгааны өөрчлөлт, хувьсал зэргийг тодруулах зорилготой тул судалгааг тодорхой хугацааны дараа дахин явуулдаг аж. Япон улсын хувьд 1992 оноос шашин шүтлэгийн талаарх судалгаанд оролцож байгаа бөгөөд 1998, 2008, 2018 онд тус тус уг судалгааг хийжээ. 2008 оны судалгаагаар, “Та шашин шүтдэг үү” гэсэн асуултад “шүтдэггүй” гэж хариулсан хувь 49,4%, буддын шашин шүтдэг 34%, шинтоо шашин 2,7%, бусад шашин 1,1%, протестант 0,7%, католик 0,2% гэж хариулжээ. Шашин шүтдэггүй хувь 49,4% байхад, шүтдэг хувь 38,7% болж байна. 2018 онд явуулсан судалгаагаар буддын шашныг 31%, шинтоо шашныг 3%, христийн шашныг 1%, бусад 1%, хариулаагүй 2%, шашин шүтдэггүй 62% гэсэн дүн гарсан байна. Мөн “Ками болон бурханд мөргөх давтамж”, “Тэнгэр бурхан харж

байгаа”, “Хүний оюун ухаанаас давсан их хүч оршдог”, “Байгальд оршдог ками”-д итгэж сүсэглэдэг хүний тоо буурч байгаа нь тодорхой болжээ.

Уг судалгааны төвийн судалгаанд уламжлалт болон шинэ шашныг салгаж оруулдаггүй байна. Тус судалгаагаар “Ками байдаг” эсэхийг асуухад “Ками байдаг гэдэгт итгэдэггүй” гэж хариулсан хүний тоо 8.7%, “Ками байдаг гэдэгт эргэлздэг ч, байдаг гэдэгт итгэдэг” гэж 11,9%, “Ками үнэхээр байдаг гэдэгт итгэдэг, ками байдаг гэдэгт эргэлздэггүй” 4,3% нь хариулсан бөгөөд ками оршин байдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг хүмүүс цөөн хувийг эзэлж байна. Харин нөгөө талаас, ками байдаг эсэхийг ч мэдэхгүй, байдаг гэдгийг мэдэх арга ч байхгүй гэх агностик байр суурьтай хүмүүс 19,2 хувийг эзэлж байна (「世界60カ国価値観データブック」).

Судалгаанд оролцогчдын 23,2% нь “Ками байдаг гэдэгт итгэдэггүй ч ямар нэгэн ер бусын хүч байдаг гэж боддог” гэж хариулсан бол, 32% нь “Зарим тохиолдолд ками байдаг гэж итгэх үе ч, итгэхгүй үе ч байдаг” гэж хариулжээ. Талаас илүү хувь нь цаг үе, нөхцөл байдлаас шалтгаалаад хүний ойлголтоос давсан шашны гэж хэлж болохоор зүйл байдаг юм шиг санагддаг гэж хариулсан байна. Мөн Камигийн оршихуйг мэдэрч, шүтэн бишрэх сэтгэлийн тухайд, 25,9% нь “Ойлгож байна”, 52,9% нь “Тодорхой хэмжээнд ойлгож байна” хэмээн хариулснаас, пантеист үзэлтэй хүмүүс ихэнх хувийг эзэлж байгааг харж болно. Шашин шүтдэггүй хүн бараг тал хувийг эзэлж байгаа ч үүнийг атеист юм уу агностик гэж шууд дүгнэх боломжгүй юм.

Соёлын хэрэг эрхлэх газраас гаргадаг “Шашны эмхэтгэл”-ийн 2021 оны дугаараас үзэхэд, 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар шинтоо шашинд итгэгчдийн тоо 87 орчим сая (48,5%), буддын шашинтнууд 83 сая гаруй (46.4%), христэд итгэгчид 1,9 сая (1,1%) бусад шашинд итгэгч 7,3 сая (4%) байна гэсэн судалгааны дүн гарчээ. Түүнчлэн нийт 180544 шашны байгууллага бүртгэгдсэн бөгөөд үүнд Боловсрол, соёл, спорт шинжлэх ухааны яамны сайд харьяанд шинтоо шашны 212, буддын шашны 483, христийн 328, бусад 124 шашны байгууллага байгаа бол, мужийн захирагчийн харьяанд байдаг шинтоо шашны 84,361, буддын шашны 76,572, христийн шашны 4492, бусад 13972 шашны байгууллага бүртгэгдсэн байдаг [日本宗教統計調査, 2022]аж. Соёлын хэрэг эрхлэх газраас шашны талаарх судалгаа хийхдээ 1.Шинтоо шашин 2.Буддын шашин 3.Христийн шашин 4.Бусад шашин гэсэн 4 төрөлд хуваан судалгаа хийдэг. Гэвч энэ нь Япон дахь шашныг 4 том төрөлд хуваадаг гэсэн үг биш юм. Шашин судлалын хувьд ч ингэж ангилал ёстой гэсэн тодорхой ангилал байдаггүй. Өмнө нь шинтоо шашны нэг урсгал байсан Тэнрикёо (天理教*) шашны байгууллага “бусад шашин” ангилалд бүртгүүлсэн байдаг.

Энэ мэтчилэн олон судалгааны дүн янз бүр гарсан байх бөгөөд ерөнхийдөө “шашин шүтдэггүй” гэж хариулсан хүний хувь өндөр байгаа ч, шүтлэг, сүсэг бишрэлтэй холбоотой асуултад далдын хүчинд итгэж, бурханд залбирдаг гэж хариулсан хүмүүсийн хувь ч цөөнгүй байгаагаас үзэхэд шүтлэггүй гэж шууд дүгнэх боломжгүй нь харагдаж байна. Эдгээр судалгааны дүн нь нийт япончуудын шашин шүтлэгийн байдлыг шууд илэрхийлэх боломжгүй гэдгийг энд дурдах нь зүйтэй.

Ийнхүү япончуудын шашин шүтлэгийн байдал тодорхой бус, шууд дүгнэх аргагүй байгаа нь тэдний “шашныг үзэх үзэл” (宗教観) -тэй нягт холбоотой учир энэ талаар тодруулав.

Япон улс хаалттай улсын бодлогыг халж, нээлттэй улс болсноор Мэижигийн үед /1868 он/ Европын соёл, шинжлэх ухаан зэрэг нэвтэрч орж ирснээр шашны нэр томьёо ч орж иржээ.

* Тэнрикёо- Японд үүссэн шашин, Мики Накаямагийн үүсгэн байгуулсан, шинтоо болон буддын шашны сургаалд үндэслэн үүсгэн байгуулсан монотеист шинэ шашны хөдөлгөөн юм. 1908 онд Японы засгийн газар хүлээн зөвшөөрсөн. Тэнрикёогийн үндэс нь дэлхийг аврахад тусалдаг Тэнри О-но-микото бурханд харилцан тусалж, үйлчилж, залбирснаар дэлхий дээрх амар амгалан, аз жаргалтай амьдралыг хэрэгжүүлэх сургаал юм.

Religion гэх нэр томъёог япон хэлэнд орчуулах шаардлага тулгарсан ч үүнд тохирох япон үг олохгүй байв. Эцэст нь, Иноүэно Тэцүжиро (井上哲次郎) тэргүүтэй гүн ухаан судлаачид 1881 онд англи хэлний гүн ухааны үг хэллэгийг японоор орчуулсан “Философийн үгийн сан” бүтээлээ хэвлүүлсэн бөгөөд religion-ыг шюүкёо (宗教) гэж орчуулжээ. Шюү (宗) нь сект, бүлэг, кёо (教) сургаал гэх хоёр ханзны нийлэмж, өөрөөр хэлбэл сектийн сургаал, номлол гэх утгатай үг юм.

Шюүкёог японоор “Ками, будда зэрэгт итгэж, амар амгаланг олохыг хичээдэг оюун санааны үйл ажиллагаа. Мөн камии болон буддын сургаал” гэсэн бол Коожинэн (広辞苑) тайлбар тольд “Ками эсвэл ямар нэгэн аугаа далдын хүчтэй хүн эсвэл ариун дагшин зүйлд итгэх итгэл, сүсэг бишрэл” [新村出, 1955] хэмээн тайлбарласан байна.

Шашныг хэрхэн үздэг талаар судлаачдын байр суурийг авч үзэхэд, Германы нийгэм, улс төр судлаач эрдэмтэн Макс Вебер (Max Weber) “Шашин гэдэг бол зан үйлийн хэв маяг юм” гэж тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, шашин гэдэг нь хүний зан үйлийг ухамсартай болон ухамсаргүйгээр жолооддог зүйлсийн ерөнхий нэр томъёо гэж тэрээр үзсэн. Цаашлаад сүсэг бишрэлийн объект болсон бурхан байдаг эсэхээс үл хамааран ёс зүй, ёс суртахуун, зан заншил, ёс заншил нь бас нэгэн төрлийн шашин юм [宇都隆史, 2015] гэж томъёолжээ.

Шашин судлаач Фүрүно Киёто (古野清人) тэргүүтэй судлаачид “Шашин нь хүн болон байгалийн хүч чадлаас давсан оршихуйд итгэх итгэл дээр тулгуурласан сэтгэлгээ, үзэл бодлын тогтолцоо [古野清人, 1978年] гэсэн бол, судлаач Мүраками Шигэёши (村上重良) “Дээрх тогтолцоонд суурилсан сургаал, зан үйл, баяр ёслол, байгууллага зэргийг багтаасан нийгмийн бүлгийг хэлнэ (村上重良, 1987) хэмээжээ.

Судлаач Ямамото Шичихэи (山本七平) Германы судлаач Макс Веберийн онолыг баримталж, “Япончууд ямар нэгэн шашны бүлгэмд төдийлөн их харьяалагддаггүй, гэхдээ тэд Японы өвөрмөц зан үйлийн хэв маягтай. Үүнийг дан ганц буддын эсвэл шинтоо шашнаар тодорхойлж болохгүй. Энэ бол Японы шашин юм” (宇都隆史, 2015) хэмээсэн байдаг.

Судлаач Үто Такаши (宇都隆史) “Шашнаас айдаг япончууд” өгүүлэлдээ “Япончуудын дийлэнх нь “шашин шүтдэггүй” гэж хариулдаг. Энэ нь тэд шашин гэдэг зүйлийн талаар сайн мэддэггүй, дунд сургуульд шашны мэдлэг олгодоггүйтэй холбоотой. Гэвч, үнэндээ япончууд шиг шашны зан үйлийг хүлээн зөвшөөрдөг, тэмдэглэдэг үндэстэн дэлхийн өөр хаана ч үгүй. Үүнийг ганцхан жишээнээс тодхон харж болно. Жилийн эцэс болоход, Христийн мэндэлсний өдрийг (Христийн шашин) тэмдэглэдэг, харин шинэ жилийн үдэш хийдийн хонхны дууг 108 удаа сонсож тэмдэглэдэг (буддын шашин), шинэ он гарснаар хамгаалагч эзэн бурхан залардаг шинтоо шашны сүмдээ очиж мөргөдөг (шинтоо шашин), өвөг дээдэстээ зориулж тахилын ширээн дээрээ зул өргөдөг(даогийн сургаал). Ердөө аравхан хоногийн дотор тэд 4 өөр шашны зан үйлийг огт төвөгшөөлгүй хийж гүйцэтгэдэг” гэсэн байна

Шашин судлаач Тэрашима Тэцүро (寺島実郎) япончуудын шашин шүтлэгт юу нөлөөлсөн талаар судалж, дараах байдлаар дүгнэсэн байдаг.

“Байгаль шүтлэг, шинтоо шашин нь япончуудын амьдралд гүн холбоотой бөгөөд тэд шинтоо шашны сүмд залбирч, ариун дагшин газруудаар очдог, шинтоо бол байгаль, өвөг дээдсээ дээдэлсэн итгэл үнэмшлийг агуулсан Японы уламжлалт шашин япончуудын шашныг үзэх үзэлд ихээхэн нөлөө үзүүлдэг. Түүнээс гадна “Шингакү (心学) гэх философийн үзэл япончуудын оюун санаанд ихээхэн нөлөө үзүүлдэг. Энэ нь шашин шүтлэгтэй шууд холбоогүй ч, хэрхэн амьдрах тухай сургаал агуулсан Японы өвөрмөц философийн санаа юм гээд, “япончууд шашин шүтлэгт төдийлөн их анхаардаггүй, учир нь тэдэнд шашны мэдлэг боловсрол олгодоггүй. Тиймээс тэд шашны талаарх мэдлэг дутмаг байдаг” гэсэн байдаг.

Тэрээр эцэст нь “Япон хүмүүс тус бүрдээ ямар нэг итгэл үнэмшил, сүсэг бишрэл тээж байдаг. Шинтоо шашны сүмд очиж аливаа зүйлийг бүтээж өгөхийг гуйн залбирч гуйдаг, мэргэ төлөгт итгэдэг зэрэг үйл хөдлөл, зэргээс нь харахад япончуудыг “шашин шүтдэггүй” гэж шууд дүгнэх боломжгүй (寺島実郎, 2021) гэсэн байна.

Ихэнх судлаачид япончуудын шашин шүтлэгийг “Япончууд шашныг ямарваа нэг шашны бүлгэм, шашны номлолтой холбон төсөөлдөг. Тиймээс ч шашин шүтдэг хүний тоо цөөн хувьтай гардаг” гэж тайлбарладаг. Учир нь япончуудын дийлэнх нь шашны гэгдэх ёслолд оролцдог ч тэд ямар нэгэн шашны байгууллагад харьяалагддаг хүний тоо цөөн байдаг аж.

Өнөөгийн Японы нийгэмд тухайн хүн ямар шашин шүтдэг болохыг анхаарч үздэггүй, хувь хүн ч өөрийн шүтлэгээ төдийлөн их ухамсарладаггүй байна. Тийм ч учраас, шашны талаарх судалгааны дүн ямар ч гарсан түүнийг няцааж, эсэргүүцэх явдал бараг л гардаггүй байна.

Шашин судлаач Ама Тошимаро (阿満利麿) 1996 онд “Япончууд яагаад шашин шүтдэггүй вэ” (阿満利麿, 1996) бүтээлдээ япончуудын шашин шүтлэгийг “бүтээгч эзэнтэй шашин”, “байгалийн шүтлэг” зэрэгтэй холбон тайлбарлажээ. Тэр бээр япончуудын “шашин шүтдэггүй” шалтгааныг тэд уламжлалт шашнаа “бүтээгч эзэнтэй шашин”-тай харьцуулдагтай холбоотой гэж үзсэн байна. Японы уламжлалт шүтлэг болох шинтоо шашин нь байгаль шүтлэг, харин буддын шашин, христийн шашин бүтээгч эзэнтэй том шашин. Хэдийгээр *Японд бүтээгч эзэнтэй шашин болох буддын шашин, христийн шашин нэвтэрч, зан үйл, сургаал номлол тодорхой хэмжээнд нөлөөлсөн ч япончууд шинтоо шашнаа сүсэг бишрэлийнхээ үндэс суурь гэж үздэг. Тиймээс том шашинтай харьцуулах боломжгүй байгаль шүтлэгтэй япончууд “шашин шүтдэггүй” гэж хариулах гол шалтгаан нь энэ юм* (阿満利麿, 1996) гэж судлаач тайлбарлажээ.

Судлаач Ямамото Шичихэи (山本七平) япончуудын шашныг тодорхойлохдоо Нихонкёо (日本教) буюу “Японы шашин” гэсэн нэр томъёог ашигласан байдаг. Шашин судлалын үүднээс авч үзэхэд, буддын шашин, күнз, христийн шашин Японд орж ирэхэд, тэдгээр шашны дагах ёстой дүрэм, хэм хэмжээг нь хасаад зөвхөн ёс суртахууны хэсгийг нь авч “Японы шашин” болгон өөрчилсөн. Өөрөөр хэлбэл, япончууд ямар нэг баяр ёслолд оролцохдоо христийн сүсэгтэн, эсвэл буддын шашинтууд шиг биш, зүгээр л “Японы шашин”-д итгэгч, сүсэгтний хувиар уг баяр ёслолд оролцдог (宇都隆史, 2015) гэсэн байна. Улмаар, судлаач “Шашин гэдэг ойлголтод шашны ямар нэг зан үйлийг байнга хийдэг, мөрддөг, залбирал мөргөл хийх үйл заавал багтдаг. Тухайлбал, лалын шашинтан өдөрт 5 удаа залбирах шаардлагатай, мацаг барих зэрэг ёсыг ягштал мөрдөх шаардлагатай болдог. Харин япончуудын хувьд, “Японы шашин”-д ийм нарийн тогтсон дэг жаяг, дүрэм журам байдаггүй нь тэдний шашныг үзэх үзэлд нь нөлөөлсөн байж болох юм гэж үзжээ.

Зохиолч Акүтагава Рюүносүкэ (芥川龍之介) “Ками нарын инээмсэглэл” бүтээлдээ “Японд гаднын шашин дэлгэрүүлэх гэж яаж ч хичээгээд амжилт олохгүй, учир нь япончуудын эрт дээр үеэс олон сая ками тахин шүтэж ирсэн, шинтоо шашинд л байдаг өвөрмөц шашныг үзэх үзлээс болоод Бурхан будда ч, Есүс Христ ч Японд орж ирвэл тэдгээр ками нарын нэг гэж үзэх болно” хэмээн бичжээ. Мөн тэрбээр гаднын улс орнуудын үзэл санааг өөрчилж, өөрийн болгох байдлыг “бүтээж, өөрчлөх хүч” хэмээн тодорхойлжээ.

Дүгнэлт

Энэ бүхнээс үзэхэд, дэлхий дахинд япончуудыг шашингүй үзэлтэн гэж үзэх үзэл хандлага их байдаг байна. Япончуудын шашин шүтлэгийн талаарх судалгааны дүнгээс үзэхэд ч, зарим судалгаанд “шашин шүтдэггүй” гэж хариулсан хүний тоо их гарах, зарим судалгаанд шинтоо шашин шүтэгчдийн хувь их, эсвэл хоёр шашныг давхар шүтдэг хүмүүс дийлэнх хувийг

эзэлдэг гээд олон янзын дүн гарсан байна. Япончуудын шашин шүтлэгт шашныг үзэх үзэлтэй нягт холбоотой байдаг нь харагдлаа. Судлаачид “шашингүй үзэлтэн” гэх үзэлтэй холбогдуулан янз бүрээр тайлбар өгсөн байдаг. Тухайлбал, япончууд уламжлалт шашнаа “бүтээгч эзэнтэй шашин”-тай харьцуулдаг учраас “шашин шүтдэггүй” гэж хариулдаг гэж үзжээ. Үүнийг өнгөц харахад тэд шашингүй үзэлтэн мэт харагдавч, үнэндээ байгаль шүтлэг болох шинтоо шашны үзэл санаан дээр суурилан гаднаас орж ирсэн буддын шашин, күнзийн сургаал, христийн шашны ёс зүй, ёс суртахууны хэсгийг нутагшуулж, эдгээр шашны зан үйлийг өргөн дэлгэр тэмдэглэдэг. Макс Веберийн онолын үүднээс япончуудын энэхүү шашны олон зан үйлийн хэв маягаас нь тайлбарлахад, тэднийг “шашин шүтлэгтэй” хүмүүс гэж дүгнэж болохоор байна. Япончууд шашин гэх ойлголтыг төдийлөн их ухамсарладаггүй, мөн энэ талаарх сургалт хангалтгүй байдагтай холбоотойгоор өөрсдийгөө “шашингүй үзэлтэн” гэж үзэхэд хүргэдэг нь ажиглагдлаа.

Түүнчлэн судлаач Ямамото Шичихэгийн “Японы шашин” гэсэн нэр томъёог ашигласан нь өнөөгийн япончуудын шашин шүтлэгийг онож хэлсэн томъёолол болсон гэж үзлээ. Учир нь “Японы шашин” гэдэгт дээрх шашны бүх зан үйл багтаж байгаа юм.

Эцэст нь дүгнэхэд, шинтоо болон буддын шашны нийлэгжих үзэгдэл олон зуун жил үргэлжилж, япончууд хоёр шашныг төдийлөн ялгаж салгаж ухамсарладаггүй зэрэг шалтгааны улмаас хоёр шашныг шүтэгчдийн давхардсан тоогоор хамгийн их хувийг эзэлж байна. Эндээс япончуудыг шинтоо шашинд итгэгч, бас буддын шашинтан ч гэж дүгнэж болохоор байна.

Ном зүй

- (n.d.). 「世界60カ国価値観データブック」. <http://www2.ttcn.ne.jp/honkawa/9460.html>.
- Т.Сансартуяа. (2009). Шинто шашны тухай өгүүлэх нь. In *Япон хэл, соёл өгүүллийн эмхэтгэл* (p. 95).
- ミルチア エリアーデ. (1994). In *エリアーデ世界宗教事典*.
- 古野清人. (1978年). In 『世界大百科事典』 14巻 (p. 231). 平凡社 .
- 宇都隆史. (2015). 「宗教」が怖い！日本人 | 松下政経塾 (mskj.or.jp).
- 寺島実郎. (2021). 戦後日本人の精神の構造 「宗教無き時代」の意味とは.
- 島田裕実. (2020). In *世界四大宗教の成り立ちとグローバルにおける影響とは* (p. 221).
- 新村出. (1955). In 『広辞苑』 (第五版) (pp. 1254-1255). 岩波書店.
- 日本国憲法. (1946). 第20条 .
- (2022). *日本宗教統計調査*. (e-stat.go.jp).
- 村上重良. (1987). In 『世界宗教事典』 (p. 4).
- 阿満利麿. (1996). 『日本人はなぜ無宗教なのか』 .

Analyzing the state of religious belief and religious attitudes of contemporary Japanese people

Foreign researchers consider the Japanese people as "non-religious" and "irreligious." According to the results of international research conducted on global religious practices, in most cases, the Japanese are perceived to be "a nation without any religion." Moreover, according to research conducted by Japanese research institutions, it is not possible to identify the religion of the Japanese people directly. For instance, a high percentage of respondents may be identified as "atheists," while those who answer to be "religious" often follow two or more faiths. In this article, we have considered the current state of the religion and the way the Japanese view religion.